

“УЛААН САХИУС”-НЫ “ХЭРЭГТНИЙГ ӨРГӨХ” УНШЛАГЫН ТУХАЙ СУДАЛГАА

Р.Дарьхүү /доктор (Ph.D), профессор/

Д.Хоролбат /гэвш, докторант/

МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Түлхүүр үгс: Жамсран, Улаан сахиус, хэрэгтнийг өргөх зохиолын тайлбар, хэрэгтнийг өргөх, Агваанчүлтэмжамц, Өндөр гэгээн Занабазар,

Товч утга: Энэхүү өгүүлэлд Өндөр гэгээн Занабазарын зохиосон “Улаан сахиусны хэрэгтнийг өргөх” зохиол дахь шашны зан үйлийг судлахыг гол зорилго болгов. Мөн Өндөр гэгээний тус бүтээлд Номгоны дара эх ламтан Агваанчүлтэмжамцын бичсэн “Номыг тэтгэгч улаан сахиусны хэрэгтнийг өргөх тахилын эрхэс лугаа сэлтийн тайлбар дээдсийн тааллын чимэг шүрэн уншлага” хэмээх тайлбарын гүн ухааны утгын талаар авч үзлээ.

Өндөр гэгээн Занабазар 10 хангалын тахилгын зан үйлд “хэрэгтнийг өргөх” хэмээх уншлагыг унших үеийн ая эгшиг, цангийн цохилтын хамт шинээр зохион нэвтрүүлсэн байна. Уншлагад мунхгийн эрхээр гардаг аминч үзэл, түүгээр үүсдэг тачаах, уурлах зэрэг сэтгэлийн хоруудын үндсийг тасалснаар гадаад дайсны хорлолыг хаана гэх буддын гүн ухааны бодь сэтгэлийн тухай үзлийг гаргасан нь уг зохиолын онцлог болжээ. Энэхүү өгүүллээрээ буддын гүн ухаан, түүний дээд анги аг тарнийн чиглэлээр тусгайлсан бүтээлүүд туурвиж байсан Занабазар гэгээний Монголын шашин, соёлд оруулсан хувь нэмрийг чухалчлан үзэв. Мөн түүний шашин, соёлын агуулгыг тэлсэн, буддын бясалгалын арга зүйг Монголын гэх өвөрмөц төрхөөр баяжуулсан болохыг нотлон харуулах ач холбогдолтой юм. Мөн Өндөр гэгээн

Занабазарын улаан сахиусны “хэрэгтнийг өргөх” уншлага дахь шашны зан үйлийг судлах, тус зохиолд Номгоны дара эх ламтан Агваанчүлтэмжамцын хийсэн тайлбарын гүн ухааны утгыг судлахыг зорилоо.

Улаан сахиусны хэрэгтнийг өргөх зохиол нь “Сүнторвү нацаг” бүтээлд бий. “Сүнторвү нацаг” нь Өндөр гэгээний зохиол бүтээлийн эмхэтгэл юм. Уг эмхэтгэлд 125 зүйл ном, бүтээл байгааг Р.Бямбаа “Монгол билэг” цувралын I ботьдоо бүртгэн бичжээ. Энэхүү эмхэтгэлийн хамгийн алдартай бүтээл нь “Цагийг тохинуулагч залбирал”¹, “Маанийг бүтээх гүн арга”², мөн зөвхөн монгол туургатнаа дэлгэрсэн “Хэрэгтнийг өргөх”³ нэрт зохиолууд юм. Эдгээр бүтээлд Төвд, Монголын олон

* Улаан сахиус. Tib. Lcam sring.

¹ Адистидын дээдийг хайрлагчид. tib.byin rlabs stsol ma. хүрээ бар 3 хуудас

² Маанийг бүтээх гүн арга. tib. mā ṇi sgrub thabs zab mo. Хүрээ бар 3 хуудас

³ Хэрэгтнийг өргөх. tib.chas 'bul. Хангалын судар. Хүрээ бар.

сэтгэгч тайлбар бичсэн байдаг.

Энэ тухай Р.Бямбаа “Монгол билэг” цувралын VI ботьдоо тус тайлбаруудыг эмхэтгэн гаргасан нь чухал эх сурвалж болжээ.

Цагийг тохинуулагч залбирал буюу “Жанлавцогзол” хэмээх зохиолын гүн ухааны үндсийг тайлбарлан, Ганжуурваа номун хаан Лувсанцүлтэм (1642-1715 он) “Адистидын дээдийг хайрлагчийн тайлбар”⁴, Жидорийн хамба лам Агваанхайдав (1779-1838 он) “Адистидын дээдийг хайрлагчид алдаршсан зохиолын тайлбар үгийн утгыг машид тодруулагч”⁵, Мөрөнгийн хүрээний аграмба Цэрэнжав (XX зуун) “Умар зүгийн өмч хувь үлэмжийн бурхан ёгачари Занабазар бээр хувь төгссөн зовлонт амьтдад бэлэг өгөн соёрхсоны цагийг зохилдуулах залбирал адистидын дээдийг хайрлагчтын өгүүлсэн утга санааг арвитгах чандмань үзэгдлийн арганд хүжийн галын гэгээ мэтийн тэмдэг зохиосон оршив”⁶ зэрэг тайлбаруудыг төвд хэл дээр зохиосон нь бий.

Мөн “Маанийг бүтээх гүн арга” хэмээх зохиолд Амдо төвдийн гүн ухаантан гүнтэн гэгээн Гончигдамбийдонмэ (1762-1823 он) “Шашны нар Жавзандамба

бээр зохиосон маанийг бүтээх аргын тайлбар гүн үзэгэл хэмээгдэх оршив”⁷, Туган гэгээн Лувсанчойжинням (1737-1802 он) “Жавзандамба Ранжин-Ишдорж бээр зохиосон маанийг бүтээх гүн аргын тайлбар гүн утгын үзлийн нүдийг нээгч хэмээгдэх оршив”⁸, Сайн ноён хан аймгийн Далай чойнхор вангийн хошууны их гэвш Ригзэнсэвжиддорж (XVIII зуун) “Маанийг бүтээх гүн аргын зарлигийн тайлбар хүссэн хэргийг гаргагч галбарваасан мод” тайлбар⁹, Монголын их хүрээний бичээч цорж Агваандоржийн (XIX зуун) “Маани бүтээх гүн аргын утга цагийн хүрдний ёс лугаа зохилдохуйяа анхааран авах ёсыг товч төдий өгүүлсэн эрдэнийн мөнх тамга хэмээгдэх оршив”¹⁰ зэрэг тайлбарууд бий.

Мөн “Улаан сахиусны “хэрэгтнийг өргөх” уншлага”-д Номгоны дара эх ламтан Агваанчүлтэмжамцын зохиосон “Номыг тэтгэгч улаан сахиусны хэрэгтнийг өргөх тахилын эрхэс лугаа сэлтийн тайлбар дээдсийн тааллын чимэг шүрэн уншлага”¹¹ хэмээх тайлбар байна.

⁴ Адистидын дээдийг хайрлагчийн тайлбар Tib. byin rlabs mchog stsol ma'i 'grel pa bzhugs so Бямбаа.Р., Монгол билэг цуврал VI боть. УБ., 2006. 4 хуудас.

⁵ Жанлавцогзолмаагийн утга санааны их чандмань эрдэнийг үзэгдэхийн төдийгөөн гэрэлтүүлэгч хүжийн галын гэрэл. Tib. byin rlabs mchog stsol mar grags pa'i 'grel pa tshig don rab gsal zhes bya ba bzhugs Сүмбүм Га боть. (Ка) 20 хуудас

⁶ Умар зүгийн өмч хувь үлэмжийн бурхан ёгачари Занабазар бээр хувь төгссөн зовлонт амьтдад бэлэг өгөн соёрхсоны цагийг зохилдуулах залбирал адистидын дээдийг хайрлагчтын өгүүлсэн утга санааг арвитгах чандмань үзэгдлийн арганд хүжийн галын гэгээ мэтийн тэмдэг зохиосон оршив. Tib. byang phyogs bgo skal lhag lha yo gi jcā na bajras nyam thag 'gro rnam la skyes bskur stsol ba'i dus bstun gsol 'debs byin rlabs mchog stsol ma'i brjod don bsam 'phel nor bu snang ba'i thabs su spos me'i snang ba lta bu'i brjed tho bkod pa bzhugs so Бямбаа.Р., Монгол билэг цуврал VI боть. УБ., 2006. 10 хуудас

⁷ Шашны нар Жавзандамба бээр зохиосон маанийг бүтээх аргын тайлбар гүн үзэгдэл хэмээгдэх оршив. Tib. bstan pa'i nyi ta rje bisun dam pas mdzad pa'i ma ni'i sgrub thabs zab mo'i 'grel pa zab mo snang ba zhes bya ba bzhugs so. Бямбаа.Р., Монгол билэг цуврал VI боть. УБ., 2006. 48 хуудас.

⁸ Жавзандамба Ранжин-Ишдорж бээр зохиосон маанийг бүтээх гүн аргын тайлбар гүн утгын үзлийн нүдийг нээгч хэмээгдэх оршив. Tib. rje bisun dam pa rang byung ye shes rdo rjes mdzad pa'i ma ni'i sgrub thabs kyi 'grel ba zab don lta ba'i mig 'byed ces bya ba bzhugs so. Бямбаа.Р., Монгол билэг цуврал VI боть. УБ., 2006.

⁹ Маани бүтээх гүн аргын бэрх тайлбар хэрэг хүсэл гарахын галбарваасан мод хэмээгдэх оршив. Tib. ma ni sgrub thabs zab mo'i dka' 'grel dgos 'dod 'byung ba'i dpag bsam khri shing zhes bya ba bzhugs so. Сүмбүм ЖА(Ка) боть 68 хуудас

¹⁰ Маани бүтээх гүн аргын утга цагийн хүрдний ёс лугаа зохилдохуйяа анхааран авах ёсыг товч төдий өгүүлсэн эрдэнийн мөнх тамга хэмээгдэх оршив. Tib. ma ni'i sgrub thabs zab mo'i don dus 'khor lugs dang mthun par nyams su len tshul mdo tsam brjod pa nor bu dga' 'khyil zhes bya ba bzhugs so. Сүмбүм ГА(га) боть 18 хуудас

¹¹ Номыг тэтгэгч улаан сахиусны хэрэгтнийг өргөх тахилын эрхэс лугаа сэлтийн тайлбар дээдсийн тааллын чимэг шүрэн уншлага. Tib. chos skyong dregs pa lcam sring gi chas dbul mchod 'pheng dang bcas pa'i 'grel ba dam pa'i dgongs rgyan byi ru'i do shal zhes bya ba bzhugs so Бямбаа.Р., Монгол билэг цуврал VI боть. УБ., 2006

Өндөр гэгээний тус бүтээл болон энэхүү тайлбар зохиолын талаар тусгайлсан судалгаа одоогоор алга байна. Ямартай ч Өндөр гэгээний Улаан сахиусны “хэрэгтнийг өргөх” зохиолыг хүрээ дэгтэй сүм хийдүүдийн уншлагын ном сударт оруулан тогтмол уншсаар иржээ. Мөн Буриадын Агийн дацан, Өвөр Монголын Алшаа хошуунд болон Долнуурын зарим хийдүүдэд ч уншиж байжээ.

Өндөр гэгээний Улаан сахиусны хэрэгтнийг өргөх¹² хэмээх зохиол нь “Сүнторву нацаг” эмхэтгэл бүтээлийн 696-73а талд байна. “Сүнторву нацаг” бүтээлийн тухай Р.Бямбаа “Монгол билэг” цувралын I ботьдоо “...хятад бартай, хуудасны дугаарыг хятад, төвдөөр бичсэн”¹³ хэмээн тайлбарласан байдаг. “Сүнторву нацаг” бүтээлийг Локеш Чандра 1982 онд Шинэ Делид “I Богдын зохиолын эмхэтгэл” нэртэйгээр гэрэл зургаар хэвлүүлжээ. Мөн Р.Бямбаа 2003 онд I-III Богдын зохиолуудыг нэгтгэн нэг боть болгон хэвлүүлсэн байна.

Арван хангал¹⁴-ын тахилгын олон янзын барын номууд байдаг. Түүний дотроос Улаан сахиусны тахилга “Номыг тэтгэгч омогт улаан сахиусны илт онол, хангах, наминчлал, магтаал, дурьтгал лугаа сэлт оршвой” 23 хуудас судар байна. Тус ном нь Мөрөнгийн хүрээнд барлагдсан, 26х19см-ийн хэмжээтэй, бичвэрийн хувьд 0.4 см, нэг хуудсанд долоон мөрөөр барлагдсан байна.

Тахилгын судрыг бүхэлд нь авч үзвэл “..гадаад төрх байдлыг дүрслэн унших буюу Ондог гэх илт онол, хоёрдугаарт урин залж авчрах Заллага, гуравдугаарт Тахил өргөх, дөрөвдүгээрт Наминчлах, тавдугаарт Өргөл өргөх, зургадугаарт Бясалгах, долдугаарт Балин өргөх, наймдугаарт Магтаал, есдүгээрт ансал (өөр төрлийн магтаал) өлзий хутаг оршуулах зэргээр залж авчирсан догшин сахиусанд сайн сайхан бүхнийг ерөөн элдэв гай түйтгэрийг арилган, хүн ардын эрүүл энх, аз жаргалтай амар тайван амьдралыг хүсэн ган зуд, гай зовлон, өвчин эмгэгээс хамгаалж төр шашинд тэрслэх дайсангүй амар төвшин байлгахыг хүсч, даатган үдэж мордуулах зан үйлийг гүйцэтгэдэг.

Нэг үгээр бол бурхан, сахиус бүрийн тахилгын зан үйл нь дээрхийн адил дараалалтай байна.”¹⁵ гэж үзжээ. Ондог гэх илт онол нь Улаан сахиусны ерөнхий дүр төрхийг илтгэсэн хэсэг юм. “..Улаан сахиусын хөмсөг хийгээд сахал нь гал мэт бадарсан байна. Тэргүүний үсний өнгө нь хул шар байх ба ар гэгзгээ боосон байна. Таван хохимой толгойг оройн чимэг титэм болгон зүүсэн байдаг нь таван хорын үндсийг дарахын бэлгэдэл болно. Цус савируулсан тавин нойтон толгойг хүзүүндээ эрхилэн зүүж мунхаг харанхуй болоод буруу үзлийг таслахын бэлгэдэл болгодог. Биеэ зэсэн хуяг хийгээд есөн улаан хадгаар чимнэ. Тэрээр өлмийдөө сайран улаан гутал өмссөн байх ба баруун хөлөө өвдгөөр нугалан тогторлогч баатрыг доош харуулан нуруун дээр нь гишгин,

¹² Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. Tib. lcamsringgichas 'bulzhesbyababzhugs so.

¹³ Бямбаа.Р. Монгол билэг цуврал. I боть. 43 хуудас.

¹⁴ Арван хангал. sam. Dasadhatmapalah. Tib. Chos skyong rnam bci.

¹⁵ С.Янжинсүрэн, Г.Хагвасүрэн “Жамсран сахиусын дүрийг урлахуйн тухайд Филисофи, шашин судлал-ХIV 184 дүгээр хуудас

зүүн хөлөө хүчтэйгээр жийсэн байна. Ийнхүү биеэ хуягласан нь түүний өөр нэг нэр Бэгз (beg tse-хуяг) хэмээхийн утгыг гаргадаг юм. Хуяг дуулгыг бие юундаа өвч асаасан нь дийлдэшгүй бат бэхийг бэлгэдэж байна гэлтэй юм”¹⁶ гэжээ.

“..Улаан сахиусны зүүн талд Рэгвийлхам /Rig pa'i lha mo/ хэмээх догшин дагина байна. Тэрээр Улаан сахиусны эхнэр бөгөөд нэг нүүр, хоёр мутартай, нүүр нь улаан, бие нь хар хөх өнгөтэй байна. Гал бадарсан үсээ мана, номин хоёроор чимэн алтан чимэг зүүж нүдээ дүрийлгэн амаа ангайсан байдаг. Тэрээр баруун мутартаа илд барин дайсны зүт далайсан, зүүн мутартаа гадас барин өтөгийг уналга болгон унасан байна.

Улаан сахиусны баруун талд Лайхансорогдаг /Lai mhan zrog bdag/ хэмээх бас нэг нөхөр нь залрах ба нэг нүүр, хоёр мутартай. Биеийн өнгө нь улаан бөгөөд баруун мутартаа илд, жадыг барин зүүн мутартаа цалам барин дайснаа оосорлосон байна. Биедээ ширэн хуяг, дуулга өмсөн галзуу чононцорыг уналга болгон унаж шөнө гүйн тогторлогч дайсныг бархиран дууддаг хэмээн төсөөлөх хэрэгтэй гэдэг. Рэгвийлхамын уналга өтөг, Лайхансорогдагийн уналга нь чоно аль аль нь хүний махан идэштэй гэдэг”¹⁷. Мөн Дитагжад буюу найман жадат хүн, хорин нэгэн Шамба буюу яргачныг дүрсэлсэн байна.

Тэгвэл хэрэгтнийг өргөх нь тавдугаарх өргөл өргөх хэсэгт хамаарагдаж байна.

Гүмбүм барын Улаан сахиусны тахилгын сударт өргөх хэсэгт ганс буюу хангах хэрэгслийн уншлагыг тусгасан бол Мөрөнгийн хүрээ барын тахилгын сударт Өндөр гэгээний зохиосон хэрэгтнийг өргөх уншлагыг нэмж оруулсан байна. Тус хэрэгтнийг өргөх зохиол нь гурван хуудас нийтдээ 72 мөр зохиол байна. Уг ном төвд хэлний цигжад буюу өлмий тэнцүүлэх аргаар бичсэн, хэмжээгээр бага боловч Улаан сахиусны зан үйлийг тодорхой гаргаж чадсан буддын шашны тарнийн зан үйлийн судар юм.

Тус зохиолын ая эгшгийн талаар Хансүр Агваанлуvsсандондүв “...лхачин Цамба болон хэрэгсэл өргөхийн аяыг Өндөр гэгээн зохиосон нь магадтай”¹⁸ хэмээн тэмдэглэсэн зэргээс үзвэл хэрэгтнийг өргөхийн ая эгшгийг Өндөр гэгээн зохиосон болох нь тодорхой байна. Улирал бүрийн эхэн, дунд сарын 29-ний хангал хуралд ая эгшиг татдаггүй. Харин адаг сард нь “өглөг эс орших” (sbyin pa mi gnas) хүртэл ая эгшиг татдаг¹⁹ тухай горим, эгшиг тэмдэглэгээ зэрэгт тодорхой дурдсан байна. Тухайлбал: Умзад Наваангомбо “..дэлгэрэнгүй хурах, их данраг өргөх²⁰ үед ая данг татаж, 15 тусгай цан²¹ цохино. Цанбын хэрэгтнийг өргөх уншлагад ая эгшиг татахад 25 цан²² цохино.

¹⁸ Агваанлуvsсандондүв “Түгээмэл эзэн гэтэлгэгч Лувсандаламбийжанцанбалсанбуугийн намтар хувь төгс нирвааныг хүсээгийн эгээрлийг хангагч баясгалангийн хурим. Төвд хүрээ барын судар., 38а-39а тал

¹⁹ Наваангомбо умзад Номыг тэтгэгч сахиусны шинэ хуучин янз төвд гар бичмэл судар.ху 4а

²⁰ Их данраг өргөх- Их үдэлт (gtang jag) гэсэн утгатай төвд үг. Хангал догшдыг тахилын сүүлд үдэж, балин өргөх зан үйл.

²¹ Тусгай цан. sphi tim/ sphi tim/ gcig tsha/ gnyis tsha/ gsum tsha/ bzhi tsha/ gcig gnyis gsum tsha

²² 25 цан. gcig tsha gnyis tsha gsum tsha lnga tsha gnyis tsha gsum tsha lnga tsha gcig tshag cig гэсэн 25 цангийн хэмнэл.

¹⁶ С.Янжинсүрэн, Г.Лхагвасүрэн “Жамсран сахиусын дүрийг урлахуйн тухайд” “Филисофи, шашин судлал XIV” 187 дугаар хуудас

¹⁷ С.Янжинсүрэн, Г.Лхагвасүрэн “Жамсран сахиусын дүрийг урлахуйн тухайд” “Филисофи, шашин судлал XIV” 187, 188 дугаар хуудас

Бусад үед хангалын нийтийн гүйлгээх эгшигээр уншиж сүндэн²³ цан цохино.”²⁴ гэж тэмдэглэжээ. Улаан сахиусны хэрэгтнийг өргөх уншлагыг хангал догшдын хангах хэрэгсэл²⁵-ийн дараа уншдаг. Улаан сахиусыг даншгийн хангал²⁶, хуучин ном²⁷ хурахад эхний өдөр “хоосон чанар бэлгэ билиг” (stong nyid ye shes), дунд болон сүүлийн өдөр “өглөг эс ориших” (sbyin pa mi gnas) хүртэл ая эгшиг татдаг. Үүнээс хойш хангалыг нийтийн ая эгшигээр гүйлгэж уншдаг.

Өндөр гэгээний “Улаан сахиусны хэрэгтнийг өргөх” зохиолд Номгоны дара эх лам Агваанчүлтэмжамц тайлбар бичсэн байдаг. Түүний бичсэн тайлбар зохиолын дэлгэрэнгүй нэр нь “Ном тэтгэгч омогт Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрх лүгээ сэлтийн тайлбар дээдсийн тааллын чимэг шүрэн сондор хэмээгдэх оришив.” (chos skyong dregs pa lcarn string gi chas dbul mchod 'phreng dang bcas pa'i 'grel ba dam pa'i dgongs rgyan byi ru'i do shal zhes bya ba bzhuks so) юм. Уг тайлбар нь 42х10см-ийн хэмжээтэй, бичвэрийн хувьд 0.5 см, нэг хуудсанд зургаан мөрөөр бичигдсэн 21 хуудас бүхий зохиол болно.

Номгоны дара эх лам Агваанчүлтэмжамцын тайлбарын бүтэц:

I. Завдал (sngon 'gro) Зохиолын удиртгал хэсэг

II. Бодит орон (dngos gzhi) Зохиолын

²³ Сүндэн- (gzun tang) Хангалын тахилгад 11 удаа цохидог түгээмэл цангийн нэр.

²⁴ Улмад Наваангомбо. Номыг тэтгэгч сахиусны шинэ хуучин эгшиг тэмдэглэгээ, төвд гар бичмэл судар

²⁵ Хангах хэрэгсэл. Сахиусны тахилгын уншлагын зан үйлийн тансарагын эд өргөх уншлагын нэр

²⁶ Данишгийн хангал. Өвлийн дунд сард бүх нийтээр 3 ба 7 хоног арван хангалыг Богдын өлмийг бататгахад зориулан хурьдаг хурлын нэр.

²⁷ Хуучин ном. Өвлийн адаг сард зурав хоног хурдаг хангал хурлын нэр

гол санаа

1. Хэрэгтнийг өргөх (chas 'bul)

a. Өргөх орныг танин бариад завсар барилдуулах (dbul yul ngos bzung ste mtshams sbyar ba)

b. Өргөх бодит ёс ('bul tshul dngos)

- Эрхин нөхөрт хэрэгтнийг өргөж үйлс даатгах (gtso bo 'khor chas 'bul zhing 'phrin las 'chol ba)

- Нөхөрт хэрэгтнийг өргөж үйлс даатгах ('khor chas 'bul zhing 'phrin las 'chol ba)

c. Өргөлийн буяны ерөөл (phul ba'i dge ba bsngo ba)

2. Тахилын эрхи (mchod 'phreng) Тахил өргөлийн хэсэг

III. Сүүлийн утга (mjug gi don) Зохиолын төгсгөл хэсэг

Зохиолын бүтцийг товч тайлбарлавал:

I. Завдал. “Намо гүрү Амиабха” буюу “Амиабха²⁸д мөргөмүй” гэж эх зохиол эхэлж байгааг Агваанчүлтэмжамц “..Улаан сахиусны хувилгаан дүрийн эцэс туйл “Цаглашгүй гэрэлт” буюу “Амиабха” бурханд буцалтгүй гурван үүдний бишрэнгүйгээр мөргөн зохиосон”²⁹ хэмээн тайлбарлаад төвд хэлт утга зохиолын дагуу тахилын шүлэг (mchod brjod)-ээр нь эх зохиол эхэлж байна гэж үзжээ.

²⁸ Амиабха. sam. Ami tabha, tib. 'od dpag med, Цаглашгүй гэрэлт гэсэн утгатай самгард үг.

²⁹ Агваанчүлтэмжамц. Ном тэтгэгч омогт Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрх лүгээ сэлтийн тайлбар дээдсийн тааллын чимэг шүрэн сондор хэмээгдэх оришив. Tib. chos skyong dregs pa lcarn string gi chas dbul mchod 'phreng dang bcas pa'i 'grel ba dam pa'i dgongs rgyan byi ru'i do shal zhes bya ba bzhuks so. 2 б тал

II. Бодит орон. Энэ нь “Хэрэгтнийг өргөх” хийгээд “Тахилын эрхи” гэсэн хоёр зүйлтэй.

1. “Хэрэгтнийг өргөх” нь гурван хэсэгтэй. Өргөх орныг танин бариад завсар барилдуулах хэмээх нь өргөх орон буюу Амиабха, Дамдин, Хаянхярваа, Улаан сахиус гурван бурханд тахилын идээ өргөхдөө эдгээр бурхдын мөн чанар адил юм хэмээн танин мэдүүлж буй хэрэг юм. Өргөх бодит ёс хэмээх нь эхлээд Улаан сахиусанд, дараа нь сахиусны юум³⁰, нөхөр сэлтэд тахил өргөх гол утгыг эхлүүлж байгаа хэрэг юм. Өргөлийн буяны ерөөл хэмээх нь тахил өргөсөн гол утгаа самади бясалгалын хүчээр хоосон чанарын агаараас бодьтой болгон өргөж байгаа хэрэг.

2. Тахилын эрхи хэмээх нь Улаан сахиусны хэрэгтнийг өргөх уншлагад огт байдаггүй боловч Улаан сахиусны тахилгын сударт бий. Мөн Өндөр гэгээний “Сүнторву Нацаг”-ийн Бээжин барын номын 56 талд орсон байна. Харин Агваанчүлтэмжамц Өндөр гэгээний айлдсан энэхүү нэг бадаг тахилын шүлгийг дунд нь оруулан тайлбарласан нь сонирхолтой. Үүнийг юуны учир энд оруулан тайлбарласан тухайгаа дурдаагүй байна.

III. Сүүлийн утга. Номгоны дара эх ламтан Агваанчүлтэмжамц сүүлийн утгыг тайлбарлалгүй “Улаан сахиусны хэрэгтнийг өргөх” зохиолын төгсгөлийн хэсгийг тэр хэвээр нь оруулжээ. Улаан сахиусны хэрэгтнийг өргөх зохиолын төгсгөл хэсэгт “...өөрийн сүжгээр мутрын

тэмдэг тэргүүтнийг шинээр бүтээн өргөх уг туурвихын хүсэл байх тийн атал хар морин аймгийн эш ургасан язгуур үндэсний шавь унзад Пунцагжанцан бээр дуртгасны тул зохиосон”³¹ хэмээн тэмдэглэжээ. Эндээс хэд, хэдэн зүйл ажиглагдаж байна. Өндөр гэгээн уг зохиолыг эртнээс зохиох хүсэлтэй байсан. Мөн Улаан сахиусыг шинээр бүтээхэд зориулан зохиосон нь тодорхой байна. Харин умзад Пунцагжанцан нь Өндөр гэгээний дотны шавь болох нь мэдэгдэж байгаа юм.

Зохиолыг дэлгэрэнгүй авч үзвэл: Зохиолын агуулгын эхний хэсгийг товчоор тайлбарласнаас өөр дэлгэрэнгүй тайлбарлаагүй байна. Иймд II-1-а хэсгээс эхлэн дэлгэрүүлэн тайлбарлая.

II-1-а. “Өргөх орныг танин бариад завсар барилдуулах” гэдэг нь эх зохиолд:

“Хязгаалиггүй гэрэлт их эрхтийн бэлгэ билгийн цэнгэлээс

Хэнийг номхотгох их хилэнтийн биеийг үзүүлэх

Омогтын аймгийн ноён эгч дүү нөхөр сэлт бөгөөд

*Баясгалан төрүүлж зохилдохын тангаргийн эд өргөх нь”*³² гэж бий. Энэ нь “Номын лагшинт” “Бурхны хамаг эрдмийн шүтээнийг хураан эс үйлдсэн номын бие буюу мөн чанарын биет”³³ Амиабха, “Төгс эдлэлийн лагшинт” “Хэнийг номхотгох их хилэнтийн биет”³⁴

³¹ Занабазар Өндөр гэгээн. “Элдэв зохиолын эмхтгэл”. бээжин бар 75 тал

³² Занабазар. Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. Tib.lcam gring gi chas 'bul zhes bya ba bzhuigs so.12 б тал

³³ Агваанчүлтэмжамц. Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрх лүгээ сэлтийн тайлбар. 36 тал

³⁴ Мөн тэнд

³⁰ Юум-пб.уит эх гэсэн утгатай төвд үг.

Хаянхярваа, “Хувилсан лагшинг”
“..амьтдыг номхотгохын тулд бие,
зарлиг, сэтгэлийг элдэв дүрд хувилгасан
хувилгаан биет”³⁵ Улаан сахиус эгч дүү
нар³⁶ нь нэгэн мөн чанартай. Эдгээрийг
баясган зохилдох, эд өргөх гэсэн утгыг
илэрхийлжээ.

II-1-b. Өргөх бодит ёс нь хоёр
хэсэгтэй.

Эрхин нөхөрт ³⁷ хэрэгтнийг өргөж
үйлс даатгах хэмээхэд илд, нум сум, хиур,
уушги зүрх, бусад хэрэгтэн зэрэг таван
зүйл өргөж үйлс даатгана.

Нэг. “Илд өргөх нь эх зохиолд:

*Догшин эрхтийн мөн чанар улаан
төмрөөс бүтэхийн*

*Аюух бөгөөд маш хилэгнэснээс
догшины хурц ирт*

*Бэлгэ билгийн их гал бадарсан их
илдээр*

*Хортныг хэсэглэн үйлдэхээр
хилэгнэсэн үүнийг*

Улаан Махагала эрхтийн хааны
мутарт өргөмүй”³⁸ гэж бий. Тайлбарт
“Тэр ч амирлангуй дэлгэрэнгүй догшин
эрхтийн дөрвөн үйлээс эхний хоёр нь хоёр
тус бүтээхийн харш нөхцөлийг арилгах
хийгээд зохилдох нөхцөл бүтээх мөн
бөгөөд хойт хоёр нь бусдыг эрхэнд эс
хурааваас зохилдох нөхцөл эс бүрдсэн ба эс
гэсгээвээс харш нөхцөл үл няцахыг үйлдэх..
улаан төмөр нь зэсийн нэр мөн боловч энд
төмрийн зүйл мөнхий хувиас

догшин ба өнгө улаан тул эрхийн үйлийг
бэлгэдэхүүе таалж нэр түүнээс өгүүлсэн
илт. Тэр мэт бөгөөс ялгуусан өөрт буй
догшин эрхтийн үйлсийн мөн чанарын
улаан төмрөөс бүтэж тэр ч их хоосон
билгийн бэлгэ билгийн мөн чанар мөнхий
мөн чанарын ялгааг далайх төдийгөөр
сүрийг ч хар зүгүүд бээр хүлцэхийн учир
өчүүхэн ч үгүйд урам хугараад эрхэндээ
хураасан тул айн машид хилэнлэж дэлдэх
төдийгөөр талхлан бүрэлгэхийн догшны
хүрэлцэхүүе таслахын хурц ир лүгээ
төгссөн шүд хийгээд үзүүрээс аймшигтай
их гал улбалзан улбалзан бадрах илдний
дүрсээр буй байдлын ялгааг” гэж бий. Энэ
нь “улаан төмөр” гэдэг нь “зэс” гэдэг утга
илэрхийлнэ. “Зэс” нь төмөр учир номхотгох
буюу хатуу үйлийг, өнгө нь улаан учир
эрхшээх хоёр үйлийн утгыг агуулж байна.
Амирлуулах³⁹, дэлгэрүүлэх⁴⁰, эрхшээх⁴¹,
номхотгох буюу хатуу⁴² дөрвөн үйлийн
амирлуулах хийгээд дэлгэрүүлэх үйл нь
харшлах шалтгааныг арилгаж, зохилдох
шалтгааныг бүтээнэ. Эрхшээх хийгээд
номхотгох үйл нь бусдыг эрхэндээ хураах,
эслэн дарах үйл юм. “Илд” нь “их хоосон
чанарын билэг билгүүн” учир далайсан
төдийд хар зүгийн дайсныг эрхэндээ
хурааж, эслэн таслах хурц ирт, үзүүр
ирэнд нь гал бадарсан, шид бүтээлийг
өгдөг учраас ийн нэрлэсэн ажээ. “Хар
зүгийн дайсан” гэдэг нь дотоод сэтгэлийн
таван хорын сэтгэл, ялангуяа билгүүний
түйтгэрийг хэлнэ.

³⁵ Мөн тэнд

³⁶ Улаан сахиус эгч дүү нар. Улаан сахиус, Рэгвилхам,
лайхансродог зэрэг гурван эгч дүү, Дитаг жад хэмээх найман
жадат, 21 шамба буюу 21 яргачин нөхөд сэтгийг хэлж байна.

³⁷ Эрхин нөхөр - Улаан сахиусыг төлөөлнө.

³⁸ Занабазар. Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. Tib.lcam string
gi chas 'bul zhes bya ba bzhugs so.12 б тал

³⁹ Амирлуулах үйл-Tib.zhi ba'i las. Өвчин зовлон, гай тогторыг
амирлуулах үйл.

⁴⁰ Дэлгэрүүлэх үйл-tib.rgyas pa'i las. Нас буян, бурхан шашиныг
дэлгэрүүлэх үйл.

⁴¹ Эрхшээх үйл-tib. dbang gi las. Гурван мянган ертөнцийг
эрхэндээ хураах үйл.

⁴² Номхотгох буюу хатуу үйл-tib. drag ba'i las. Өвчин ад зэргийг
хүчээр номхотгох үйл.

Илдний шид бүтээлийг магтаад, Улаан сахиусны баруун мутарт өргөнө.

Эх зохиолд:

Авч шашин хийгээд шашин баригчид тэрсэлдэх бөгөөд

Намайг хорлогч нисванис дайсан тогтор бүхнийг

Хэсэглэн гэтэлгэхийн үйлс зохио” гэжээ. “Үйлсийг захирах” (*phrin las*)⁴³ нь хэрэгтнийг өргөснөөр хүссэн хэргийг бүтээж өгөхийг даатгасан хэсэг юм. Тайлбарт:

“Илд ба бүрний бишрэл өөр өөрийн сэтгэлчлэн энэрэнгүйгээр минимхийлэн авч бодитой шашин ба шашин баригч дээд төрөлхтөнүүдийн бие, нас, зохиол, үйлс хийгээд үндэслэлээс дороги болсон хамаг амьтны тус амгаланд тэрсэлж хорлохын сэтгэл барилдуулах лугаа төгсгөж ёгачари би бээр амьтны тусад бодь бүтээхийн мөрийн мөн чанарын гишүүн гадаад дотоодын хэрэгсэл лүгээ сэлтэд язгуур үндэс аль болохоор саад хийхийн таван язгуурыг үйлдсэн, эдүгээ үйлдэх, хожим үйлдэхийг сэтгэхийн нисванис тэргүүтэн гадаад дотоодын дайсан тогторыг зөөлнөөр номхотгохыг үл хүсэгчдийн биеийг зуу мянган хэсэг таслах бөгөөд тийн мэдлийн номын агаарт гэтэлгэхийн үйлс мөнхүү эдүгээ зохиогтун хэмээсэн мөн бөгөөд магад утгын илдээр дотоодын дайсан тогторыг номын агаарт гэтэлгэх ёс”⁴⁴ гэсэн нь илдийг Улаан сахиусанд өргөснөөр нэг талаас сүжиглэгч шавь, нөгөө талаас

Улаан сахиус тааллын тангарагийн дагуу шавийг нигүүлсэн болгооно. Үүний хүчээр шашин хийгээд шашныг баригч дээдсийн нас, үйл, үйлс, улмаар эх болсон амьтан бүгдэд тус амгалан оршихуйд саад болсон, хорлох сэтгэл үүсгэсэн аливаа саад зэтгэр бүхнийг арилгана гэж үздэг.

Улаан сахиусанд залбирснаар амьтны тусыг бүтээх, саад зэтгэр, өмнө үйлдсэн, одоо үйлдэж байгаа, хойшид үйлдэхийг санаархсан нисваанис тэргүүтэн дотно, гадна дайсны тогторыг зуу, мянган хэсэг болгон тасчиж, хоосон чанарын агаарт гэтэлгэх үйлсийг зохиогтун хэмээсэн утга санааг илэрхийлж байна.

Эх зохиолд нум сум, хиур, уушги зүрх, бусад хэрэгтэн зэрэг хэрэгсэл өргөх бүрт “Авч (X) бөгөөд, Намайг (X) бүхнийг, Онъсонд хатгаж (X)” хэмээн товчилжээ. Энэ нь “Илд өргөх” хэсгийн сүүлийн мөрийн эхний үгийг өөрчлөн “Үйлсийг захирах нь”-ийг давтсан санаа байна.

Хоёр. Нум сум өргөх нь эх зохиолд:

“Очрын хад адил их арга нум

Дээрх хүчит билиг сум

Хослон орж барилдах тул хорт нисванисын

Онъснуудыг нэгэн хамт нэвтлэхэд хилэглэсэн энэ

Гэтэлгэгч жин (*gying*) эрхтийн хааны мутарт өргөмүй”⁴⁵ гэж бий.

Тайлбарт. “Арга их амгалангийн бэлгэ билиг ч мөн чанар бэхлэгийн хувиас очрын хад лугаа адил “дханү” (*dha nu*) бөгөөд нум, билиг хоосон чанарт орохын бэлгэ

⁴³ Занабазар. Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. *Tib.lcam sring gi chas 'bul zhes bya ba bzhugs so.13 a tal*

⁴⁴ Агваанчүлэмжамц. Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрх лүгээ сэлтийн тайлбар. 66 тал

⁴⁵ Занабазар. Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. *Tib.lcam sring gi chas 'bul zhes bya ba bzhugs so 13 a tal*

билгийн мөн чанар тэргүүлгийг бүрэлгэх тул аянгын хүч лүгээ төгссөн томара (to ta ra) бөгөөд сум, тэр хоёр хослон орох ёсыг сайтар мэдэхийн хувилгааны барилдлагаар харвасан цагт нисванис тэргүүтэн гадаад дотоодын хортнуудын алийг нэвтэлбээс жич үл босч ашид үхэхүеэ болохын амины оньсыг хайрлагсадыг мөнхүү нэгэн хамт нэвтлэхэд машид хилэнлэх үйл лүгээ төгссөн энэ хоёр гадаад дотоодын хортнуудыг ашинаар гэтэлгэн үйлдэхийн жин бөгөөд тангарагт ... зарцлах ягчис их амгалан эрхтийн хааны мутрын бэлгэд өргөх болой.”⁴⁶ гэжээ. Аг тарнийн ёсонд арга буюу их амгалан, билэг буюу хоосон чанарыг хослон барилдуулахыг чухалчилдаг. Аргын мөн чанартай бат бөх очир алмаз адил дану⁴⁷ буюу нум, билгийн мөн чанартай хаана туссан ч, юуг ч нэвтэлж чадах тэнгэрийн аянга адил хүчтэй домар⁴⁸ буюу сумыг хослон барилдуулах ёсыг сайтар мэдэх оньсоор найруулан харвах цагт нисваанис тэргүүтэн дотно, гадны хортонд тусаж, арилгах увидсыг гол болгожээ. Үүнийг Улаан сахиусны мутарт өргөж байна.

Гурав. Хиур өргөх нь эх зохиолд:

“Хоосон чанарын бэлгэ билгийн жадны үзүүр огторгуйд хурч

Зоригдошгүй өршөөнгүйн их дарцаг хотол түгмэл хөдөлж

Тангарагт удирдагч хортны зүрхийг хатгахын

Байлдаанаас сайтар ялахын энэ

хийрийг

Амины эзэн эрхтийн хааны мутарт өргөмүй.”⁴⁹

Тайлбарт “Билиг хоосон чанар онохын бэлгэ билгийн мөн чанар шүрэн бэрээнд шүтсэн хурц хирс жадны үзүүр огторгуйн цаад хязгаарт хурч түүн лүгээ барилдсан арга зоригдошгүйн их өршөөнгүйн мөн чанарт аюулт их хийр хотол гэгээн завсарт түгмэл дэрвэлзэн хөдөлснөөр тангарагтны бүтээгч бээр чандын гадаад, дотоодын байлдаанд орвоос халирах хийгээд мятах өчүүхэн ч үл хэрэглэхүеэ шув шулуухан орсноор болохын хошууч буюу удирдагч баатрын бэлгэ тэмдэг эс бөгөөс тангарагт номыг тэтгэгч сахиусны цэргийн чуулган чандын тэмцлийн хар зүгийн өмөг лүгээ байлдаас хошууч болж гадаад, дотоодын хортон бүгдийн цагаан, хар зүрхний завсарт хатгаж алахад төрвөлгүй тул үл зохилдохын байлдаанд ялагдагсдыг эрхэндээ хурааж ялахад ялсныг өнөд зохиосон энэ их хийр гадаад, дотоодын

тангараг буурсан бүхэн ба улс бүгдийн амь амьсгалыг эрхиээхийн эзэн ягчис их амгалан эрхтийн хааны мутарт өргөх болой”⁵⁰ гэжээ. Эхний хоёр мөрд дайснаа дарах тарнийн ёсны арга билгийн билэгдэл туг өргөж байна. Хурц үзүүртэй, ширэн бариултай жад нь билиг. Намиран хийссэн торгон хиур нь арга юм. Энэ нь номыг тэтгэгч сахиусны цэргийн чуулганы тэмцэлдэгч хар зүгийн сүр хүч хийгээд дайныг дарах бэлгэдэл.

⁴⁶ Агваанчүлтэмжамц. Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрх лүгээ сэлтийн тайлбар. 66-7а

⁴⁷ Дану. Арга буюу их амгаланга билэгдсэн нум гэсэн утгыг илэрхийлсэн самгард үг

⁴⁸ Домар. билэг буюу хоосон чанрыг билэгдсэн сум гэсэн утгыг илэрхийлсэн самгард үг

⁴⁹ Занабазар. Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. Tib.lcam string gi chas 'bul zhes bya ba bzhus so.13 a тал

⁵⁰ Агваанчүлтэмжамц. Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрх лүгээ сэлтийн тайлбар. 9а тал

Жад нь дотно гадны хортон бүгдийн хар цагаан сэтгэлийн завсраар хатган дайныг ялж, эрхэндээ хураах гэсэн утгатай. Ялагдсан талыг ч жаргааж, эрхэндээ хураагч Улаан сахиусанд өргөө гэсэн санаа юм.

Дөрөв. Уушги зүрх өргөх нь эх зохиолд:

*“Арван орны дайсан тогторыг
тонилгохын уушиг, зүрх, цус*

*Мах, яс тэргүүтэн хэдий чинээ
тахилын эд*

*Арилсан онол бадрахын цувиралгүй
бэлгэ билгийн*

*Рашааны далайн чуулган энэ дээд
тахилыг*

*Их цогт эрхтийн хааныг баясгахын
тул өргөмүй”⁵¹ гэж бий.*

Тайлбарт “..энэ нь гадаад мэт бөгөөс цогт ламын биеийг доромжилбоос Бурханы шашин эвдрэх тэргүүтэн тонилгохын арван орон бүрдсэн хүн тэргүүтэн дайсан ба ад тэргүүтэн тогторуудыг урьдах илд тэргүүтнээр тонилгож түүний халуун уушиг, зүрх тэргүүтэн тахилын эд бөгөөд амь, би, омог, хатуу догшин явдалтнууд юунд баясгахын идээ зохиосон хэдий чинээ тэднийг тарни хийгээд даяаны үүднээс гурван очрын мөн чанарт арилсан онол бадрах гурвыг үйлдсэн барагдахыг үл мэдэх рашааны их амгалан далайн чуулганы энэхүү дээд тахилыг үтэр түргэн хатуу хүчит их цог лугаа төгссөн ягчис эрхтийн хааны сэтгэлд баясгалан төрүүлэхийн тулд идээн тахил

өргөх болой”⁵² гэжээ. Шашныг баригч лам дээдсийн лагшинд халдсан, бурхны шашныг доройтуулсан зэрэг дайснуудыг өмнөх илдээр гэтэлгэх юм. Тэдний бүлээн зүрх, уушги тэргүүтнийг тахил болгон хэрцгий догшдыг баясгах зоог идээ болгон өргөнө.

Тэдгээрийг арвис тарни, самади, чагжа буюу бие, хэл, сэтгэлийн үүднээс өргөх тахилаа ариусган, рашаан болгон адислана. Мөн тэдгээрийг хязгааргүй олон болгож арвижуулах үйлийг хийнэ. Тэр рашаан барагдашгүй их амгалангийн чуулганы хүрдний тахилын дээд болно. Үүнийг догшин Улаан сахиусыг баясгахын тулд тахил болгон өргөх юм.

Тав. Хэрэгсэл бусад нугуудыг өргөх нь эх зохиолд:

*“Хүний орон эгээрлээс хагацсан
хязгаарлашгүй чимэгт өглөгийг*

*Сайтар арилсан эрэмшилгүй
шагшаабадын улаан торгон дээл*

Хэр мэт үгүй бөх хүлцэнгүйн хуяг

Алжаахгүй хичээнгүйн саарин гутал

Хөдлөшгүй амтат самадийн дэвсгэр

Түйтгэргүй билгийн бэлгэ билгийн гал

*Бус бас хоцролгүй хязгаалшгүй
тахилын үүл*

*Лам итгэлд ялгаагүй баясгалан
төрүүлэхийн тул өргөмүй”⁵³*

Тайлбарт “..ер бусын амгалан хоосны бэлгэ билгийг үйлдэх үйлийн няцлагаар ялгах зургаан барамидуудын зэрэг мэт

⁵¹ Занабазар. Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. Tib.lcam sring gi chas 'bul zhes bya ba bzhuys so.13 б тал

⁵² Агваанчүлтэмжамц. Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрих лүгээ сэлтийн тайлбар. 11 а тал

⁵³ Занабазар. Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. Tib.lcam sring gi chas 'bul zhes bya ba bzhuys so. 13 б тал

хатсан, нойтон гавал эрх, эрдэнэ хийгээд ясан сайхан чимэг, хооловч, бугуйвч, бүс, оймс тэргүүтэн доороос илт үл гарахын чимэг ба чухал эдлэлийн хязгаалиггүй сэтгэлд таатай зүйл бөгөөд аймшигтайд үзэсгэлэнтэй бөгөөд жийргэмсэгтүүд хийгээд үзэсгэлэнтэй бөгөөд сүртэй улаан торгон хэвнэг дэрвэлзэн хөдлөх хийгээд чандын тэмцлийн мэсийн хур бээр үл нэвтрэх бөх бөгөөд бат зэсэн хуяг дуулга ба оройд аймшигтай хөдлөх дарцаг бүхий голти нарны жавхлант гэрэл бадарсан хирс дуулга хийгээд чандмань ба алтан угалзаар чимсэн улаан саарин гутал, оймс сэтгэл булаах хийгээд хаана орисоноор машид баатрын дүр тодорхоёо үйлдэх эл дайсны шинэ хуучин олон амт давхарласан дэвсгэр ба хэний бие лүгээ нөхцсөнөөр хортнуудыг үнс болгон эвдрэх цагийн гал мэтийн бэлгэ билгийн галын өмөг машид бадарснууд гараад.. тэдгээр төдийгөөр үл барагдан бус бас гадаад, дотоодын чухал эдлэл, хөгжим, өлзий хутгийн тэмдэгт эд, долоон зүйл эрдэнэ, таван зүйл хүсэл жаргалан, гадаад, дотоод, нууц ба бие, зарлиг, сэтгэлийн шүтээн эд тэргүүтэн өргөхүеэ зохистын гадаад, дотоод, нууц мөн чанарын хамаг сайн тахилын үүл тангаргийн эд хязгаалиггүй нүдээр үзэхүүд хоцролгүеэ хутагт дээд номын богдын итгэлийн хангалд “Язгуур үндэслэсэн ламаас хангах болтугай” хэмээн тахилын үүл цацрах ёсны оньс төгсөхүеэ номлосон үнэмлэхүй мэт дэлгэрсэн бөгөөд гурван аврал бүхнийг хураасны мөн чанар лам хийгээд улаан Махагала эрхтийн хаан ялгааг үл ялгах нөхөр лүгээ сэлтийн сэтгэлд цувиралгүйн амгалангаар баясгалан төрүүлэхийн тулд өргөх болой

хэмээсэн болой.”⁵⁴Гэжээ. Бодьсадын зургаан билэг бирамид байдаг. “Өглөгийн бирамид” нь үнэнд шунаснаар үл орших билгүүнээр эзлэгдэх ба хариу хийгээд үйлийн боловсрол дор хариу үл нэхэх. “Шагшаабад” нь хөөрөмсөх сэтгэлгүй, үнэнч шударга, гэм уналаар ариуссан байх. “Тэвчээр” нь аливаа гоё сайхан зүйлийг хуурамч, зүүд зэрэглээ мэт гэдгийг мэдээд тэвчээрийг бясалгах. “Хичээнгүй” нь аливаа зүйлд нэгэн чигт сэтгэлээр тууштай хандах. “Самади” нь бодь сэтгэлийг үнэнд барьж өөр зүйлд сатааралгүй төвлөрөх. “Билэг” нь хоосон чанарыг оносон билэг билгүүн сэтгэлийг үүсгэх. Энэхүү зургаан билэг бирамидыг тарнийн ёсонд дараахь байдлаар төлөөлүүлэн өргөдөг. Тэдгээр нь нойтон толгойн гавал, эрдэнэ болон ясан чимэг, хоолойн чимэг, бөгж, бүс, гутал зэрэг юм. Мөн бусад хэрэгслүүдийг хамтад нь өргөдөг. Эдгээр нь илэрхий гараагүй чимэг, ойр явдлын сэтгэлд зохистой буюу үзэсгэлэнтэй, сэтгэлд зохисгүй буюу аймшигтай, намирсан улаан торгон нөмрөг, мэс үл нэвтрэх бат бөх зэс хөө хуяг, унжлага, алтан шармал дуулга, чандмань, алтан угалзаар хээлсэн улаан булигааран гутал, хүн, адууны хүүр бүхий дайны сүр хүчийг илтгэсэн суудал, хортон дайсныг үнсэн товрог болгох чадалтай машид бадарсан билгийн гал байна. Түүгээр ч барахгүй найман тахил, эрдэнийн долоон зүйл, хүслийн таван зүйл, дотно, гадна, нууц хийгээд лагшин, зарлиг, тааллын шүтээний эд тэргүүтнийг өргөвөл зохистой. Мөн гадна, дотно, нууц, самадийн тахилын эд, мэлмийг болгоогч хязгааргүйг аврал бүхэн хурсан

⁵⁴ Агваанчүлтэмжамц. Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрх лүгээ сэлтийн тайлбар. 12 а тал

мөн чанартай Улаан сахиус нөхөд сэлтийн тааллыг баясгахын тулд өргөж байна. Түүнийг өргөснөөр хилэнц түйтгэрээс хагацаж бурхны хутгийг олох юм.

Нөхөрт хэрэгтнийг өргөж үйлс даатгах нь хоёр хэсэгтэй. Үүнд:

1. Нөхөрт хэрэгтнийг өргөж үйлс даатгах нь бүжгийн эрхт эхэд⁵⁵ хэрэгтнийг өргөж үйлс даатгах,

2. Амины эзэн улаан их хүчтэд⁵⁶ хэрэгтнийг өргөж үйлс даатгах гэсэн зүйлтэй.

1. Гурван цагийн ялгуусан ганц эх их хоосон билгийн чанадад хүргэгч туйлын их амгалангийн билгийн номын мөн чанарт урвалт үгүй орших хийгээд ахуй эрхшээх, хатуу үйлийг хослон баригч үйлсийг голчлон зохиогчийн лагшингийн өнгө хөхөмдөг улаан хоншоортой догшин охин тэнгэрийн дүртэй эхнэрт хэрэгсэл өргөх нь эх зохиолд:

“Далайсан төдийгөөр дайсны үндсийг таслагч бөгөөд

Дэлдэх төдийгөөр тоггорын чуулганыг дарагчийн

Бадрангуй зэс хутга, аянга пүрэв хийгээд

Аймишигт үтэр түргэн зовиургүй шар өтөг үүнийг

Их эх улаан нүүрт охин тэнгэрийг баясгахын тул өргөмүй”⁵⁷ гэж бий.

⁵⁵ Бүжгийн эрхт эхэд. *Tib. Улаан сахиусны юм Рэгвилхамыг хэлсэн байна*

⁵⁶ Амины эзэн улаан их хүчтэд. *Tib. Улаан сахиусны зарлыг дагагч Лайхансродогийг хэссэн байна.*

⁵⁷ Занабазар. *Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. Tib. lcam sring gi chas 'bul zhes bya ba bzugs so 14 a*

Тайлбарт “..энд ч бэлгэ билгийн илд ба үйлсийн пүрэв хийгээд өршөөнгүйн унаа лугаа барилдуулсны дотор номлогдохуунд буй боловч язгуурын үгэнд тодорхойгүй тул эс дэлгэрсэн бөгөөд номыг тэтгэгч Жамсран энэ хоёрт эрхэн нөхрийн ялгаа ерөнхийдөө үгүй боловч үед буух хэргийн эрхээс аль болох нэгнийг эрхлэн үйлдээд нэг нөхрийн ёсыг бүтээх болохыг онцгойлсон буйг номлосон чилэн энд чухам ахыг эрхлэн зохиосон бөгөөд дээдсүүдийн гарын авлагад энэхүүгийн ихэнх буй болой.”⁵⁸ гэжээ. “Илд” нь билэг, “гадас” нь үйлс, “уналга” нь нигүүлсэхүйг бэлгэдэх ёс бий. Гэвч энэ үед эх зохиолд магтсан дагуу түүний үйлсийг бүтээгч бүжгийн эрхт эх буюу Рэгвилхам бурханд хэрэгтнийг өргөж байна.

2. Эгч дүү хоёрын зарлигийг үйлдэгчийн эрхэм улаан амины эзэн их хүчит дор хэрэгсэл өргөх бөгөөд үйлсийг захирах нь эх зохиолд:

“Далайхаар шулмын аймгийн өмөг сэлтийг эцэлгэгч бөгөөд

Дэлдэхээр хортныг агиинд хүлэгчийн Хирс хийр, бэх улаан цалам ба

Цахилгаан мэт үтэр түргэн галзуу чононцор үүнийг

Үйл үйлдэгч амины эзэн улааны хэрэгтнийг өргөмүй

Авч шашинд сүсэглэж

Үнсний нарийн тоос мэт бүрэлгэн зохио”⁵⁹ гэж бий.

Тайлбарт “..номлосон бөгөөд

⁵⁸ Агваанчүлтэмжамц. *Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрх лүгээ сэлтийн тайлбар. 16 б тал*

⁵⁹ Занабазар. *Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. Tib. lcam sring gi chas 'bul zhes bya ba bzugs so. 14 б*

чононирын хэлний тусгал жамвука (*jamvika*) хэмээх үнэгэнд ч орох тул зарим үед үнэгийг чононирын дуугаар номлосон ч буй боловч энэ нь чоно хийгээд цөөвөр хоёрын хураангуйгаас болох чонын өвөрмөцөд багтах тэр мөн хэмээн номлосон болой”⁶⁰ гэжээ.

Энэ үед чоно, цөөвөр чоно хоёрын дундаас гарсан эрлийз чоныг өргөж байна. Агваанчүлтэмжамц тайлбартаа энэ үеийг нарийвчлан тайлбарлаагүй ажээ.

II-1-с. Өргөлийн буяныг зориулах нь эх зохиолд:

“Тэр мэт номын агаарт бүжгийн эрхтийг үзүүлсэн их тэтгэгч

Номын агаар их амгалан лугаа зохилдохын дээд эдээр

Номын агаарт сацрах хагацах ялгаагүй тахил үйлдсэнээр

Урвалтгүй номын агаарт хоёр тус өөсөө бүтэх болтугай

Гурван дээд лам бурхны адистид ба

Номын агаар л урвахын бэлгэ хуурмаггүйн хүчээр

Ба бүрэн бишрэх номыг сахигчийн үйлсээр

*Өлзий хутгийн сайн чуулган бүхэн түгмэл болтугай.”*⁶¹ гэж бий.

Тайлбарт “Тэр мэт түйтгэрээс хагацсан номын биеийн агаараас догшны биеийг бүтээсэн бүжгийн эрхт Хязгаалиггүй гэрэлтийн мөн чанараар ялгуусны шашныг сахин тэтгэхийн

эрхт их ягчис Бэгз эгч дүү нөхөр лүгээ сэлтэд хэмээн тахилын орон, номын агаар их амгалангийн мөнхүү бэлгэ билиг нүдний хувилгаан мэт олон дүр гарах зохилдохын дээд эдээр хэмээн тахилын эд, номын агаарт сацрах хамаг лугаа хагацсан их амгалан лугаа ялгаагүй бөгөөд түүний сүсэгт тахил үйлдэх тул хэмээн тахилын үйл бөгөөд тахилын гурван хүрд амгалан хоосон дээдийн тэмдэглэснээс үл хэтрэхүеэ үйлдэх их нууц мөрийн амийг хайрлах түүнийг үзүүлсэн.”⁶² гэжээ.

Өмнө үзүүлсэн амирлангуй дүрт Амитабха, түүний догшин дүр Хаянхярваа, түүний зарлигийг дагагч Улаан сахиус, бүжгийн эрхт эх буюу Рэгвийлхам, эрхэм улаан амины эзэн буюу Лайхансорогдаг, Дитаг жад хэмээх найман жадат, 21 шамба буюу 21 яргачин зэрэг “тахилын орон” юм.

Номын чанар их амгалангийн билэг зохилдох тангаргийн эд хэмээх “тахилын эд”. Номын дуршил бүгдээс хагацсан их амгалан лугаа ялгал үгүй мөн чанартай “тахигч” байна. Энэ гурвыг чухалчлах нь их нууц зам мөрийн амин зүйл гэж ихэд нууцлан дэлгэрэнгүй тайлбарлаагүй байна.

III. Сүүлийн утга. Үүнийг өмнө нь товч утгаар тайлбарласан.

Өндөр гэгээний “хэрэгтнийг өргөх” уншлагыг дүгнэн хэлбэл:

-Өндөр гэгээн Занабазар 10 хангалын тахилгын зан үйлд “Хэрэгтнийг өргөх” хэмээх уншлагыг шинээр оруулсан;

⁶⁰ Агваанчүлтэмжамц. Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрхт лүгээ сэлтийн тайлбар 16 б

⁶¹ Занабазар. Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. *Tib.lcam string gi chas 'bul zhes bya ba bzhuks so.* 14 б

⁶² Агваанчүлтэмжамц. Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрхт лүгээ сэлтийн тайлбар 17 а

-Ингэхдээ тус уншлагад ая эгшиг, цангийн цохилтыг тусгайлан найруулан зохиосон;

-“Хэрэгтнийг өргөх” уншлага нь Монголын сүм, хийдүүдийн уншлагад суурьшсан

-Уншлагад мунхгийн эрхээр гардаг аминч үзэл, түүгээр үүсдэг тачаах, уурлах зэрэг сэтгэлийн хоруудын үндсийг тасласнаар гадаад дайсны хорлолыг хаана гэх буддын гүн ухааны бодь сэтгэлийн тухай үзлийг гаргасан зэрэг онцлогтой болно.

Энэ өгүүллээр Монголын шашин, соёлын зүтгэлтэн Өндөр гэгээн Занабазар бээр буддын гүн ухаан, түүний дээд анги аг тарнийн чиглэл, бясалгалын арга зүйг эзэмшсэн байсныг нотлон харуулах ородлого хийсэн болно.

НОМ ЗҮЙ

1. Өндөр гэгээн Занабазар. Адистидын дээдийг хайрлагчид. tib.byin rlabs stsol ma. Хүрээ бар
2. Өндөр гэгээн Занабазар. Маанийг бүтээх гүн арга. tib. mā ṇi sgrub thabs zab mo. Хүрээ бар
3. Өндөр гэгээн Занабазар. Хэрэгтнийг өргөх. tib.chas 'bul. Хангалын судар. Хүрээ бар
4. Лувсанцүлтэм. Адистидын дээдийг хайрлагчийн тайлбар Tib.byin rlabs mchog stsol ma'i 'grel pa bzhugs so Бямбаа.Р., Монгол билэг цуврал VI боть.УБ., 2006. 4 хуудас.
5. Агваанхайдав. Умар зүгийн өмч

хувь үлэмжийн бурхан ёгачари Занабазар бээр хувь төгссөн зовлонт амьтдад бэлэг өгөн соёрхсоны цагийг зохилдуулах залбирал адистидын дээдийг хайрлагчтын өгүүлсэн утга санааг арвитгах чандмань үзэгдлийн арганд хүжийн галын гэгээ мэтийн тэмдэг зохиосон оршив. Tib.byang phyogs bgo skal lhag lha yo gi jcā na bajras nyam thag 'gro rnam la skyes bskur stsol ba'i dus bstun gsol 'debs byin rlabs mchog stsol ma'i brjod don bsam 'phel nor bu snang ba'i thabs su spos me'i snang ba lta bu'i brjed tho bkod pa bzhugs so Бямбаа.Р., Монгол билэг цуврал VI боть.УБ., 2006.”

6. Мөрөнгийн хүрээний аграмба Цэрэнжав. “Умар зүгийн өмч хувь үлэмжийн бурхан ёгачари Занабазар бээр хувь төгссөн зовлонт амьтдад бэлэг өгөн соёрхсоны цагийг зохилдуулах залбирал адистидын дээдийг хайрлагчтын өгүүлсэн утга санааг арвитгах чандмань үзэгдлийн арганд хүжийн галын гэгээ мэтийн тэмдэг зохиосон оршив” Tib.byang phyogs bgo skal lhag lha yo gi jcā na bajras nyam thag 'gro rnam la skyes bskur stsol ba'i dus bstun gsol 'debs byin rlabs mchog stsol ma'i brjod don bsam 'phel nor bu snang ba'i thabs su spos me'i snang ba lta bu'i brjed tho bkod pa bzhugs so Бямбаа.Р., Монгол билэг цуврал VI боть.УБ., 2006.
7. Гүнтэн гэгээн Гончигдамбийдонмэ. Шашны нар Жавзандамба бээр зохиосон маанийн бүтээх аргын тайлбар гүн үзэгдэл хэмээгдэх оршив. Tib.bstan pa'i nyi ma rje btsun dam pas

- mdzad pa'i ma ni'i sgrub thabs zab mo'i 'grel pa zab mo snang ba zhes bya ba bzugs so. Бямбаа.Р., Монгол билэг цуврал VI боть.УБ., 2006.
8. Туган гэгээн Лувсанчойжинням. Жавзандамба Ранжин-Ишдорж бээр зохиосон маанийн бүтээх гүн аргын тайлбар гүн утгын үзлийн нүдийг нээгч хэмээгдэх оршив. Tib. rje btsun dam pa rang byung ye shes rdo rjes mdzad pa'i ma ni'i sgrub thabs kyi 'grel ba zab don lta ba'i mig 'byed ces bya ba bzugs so. Бямбаа.Р., Монгол билэг цуврал VI боть.УБ., 2006.
 9. Ригзэнсэвжиддорж. Маани бүтээх гүн аргын бэрх тайлбар хэрэг хүсэл гарахын галбарвасан мод хэмээгдэх оршив. Tib. ma ni sgrub thabs zab mo'i dka' 'grel dgos 'dod 'byung ba'i dpag bsam khri shing zhes bya ba bzugs so. Сүмбүм ЖА(Са) боть
 10. Агваандорж. Маани бүтээх гүн аргын утга цагийн хүрдний ёс лугаа зохилдохуяа анхааран авах ёсыг товч төдий өгүүлсэн эрдэнийн мөнх тамга хэмээгдэх оршив. Tib. ma ni'i sgrub thabs zab mo'i don dus 'khor lugs dang mthun par nyams su len tshul mdo tsam brjod pa nor bu dga' 'khyil zhes bya ba bzugs so. Сүмбүм ГА(ga) боть
 11. Номыг тэтгэгч улаан сахиусны хэрэгтнийг өргөх тахилын эрхэс лугаа сэлтийн тайлбар дээдсийн тааллын чимэг шүрэн уншлага. Tib. chos skyong dregs pa lcam sring gi chas dbul mchod 'phreng dang bcas pa'i 'grel ba dam pa'i dgongs rgyan byi ru'i do shal zhes bya ba bzugs so Бямбаа.Р., Монгол билэг цуврал VI боть.УБ., 2006
 12. Улаан сахиусны хэрэгтнийг өргөх. Tib. lcam sring gichas 'bulzhes bya babzugs so. Бямбаа.Р. Монгол билэг цуврал. I боть
 13. А г в а а н л у в с а н д о н д ү в “Түгээмэл эзэн гэтэлгэгч Лувсандамбийжанцанбалсанбуугийн намтар хувь төгс нирвааныг хүсэгчийн эгээрлийг хангагч баясгалангийн хурим. Төвд хүрээ барын судар.
 14. Наваангомбо умзад Номыг тэтгэгч сахиусны шинэ хуучин янег төвд гар бичмэл судар.
 15. Агваанчүлтэмжамц. *Ном тэтгэгч омогт Жамсрангийн хэрэгтнийг өргөх тахилын эрх лүгээ сэлтийн тайлбар дээдсийн тааллын чимэг шүрэн сондор хэмээгдэх оршив.* Tib. chos skyong dregs pa lcam sring gi chas dbul mchod 'phreng dang bcas pa'i 'grel ba dam pa'i dgongs rgyan byi ru'i do shal zhes bya ba bzugs so.
 16. Занабазар. “Элдэв зохиолын эмхтгэл” бээжин бар.
 17. С.Янжинсүрэн, Г.Лхагвасүрэн “Жамсран сахиусын дүрийг урлахуйн тухайд Филисофи, шашин судлал-XIV.

ABSTRACT

Undur Gegeen Zanabazar's text, titled, "Offering All Fulfilments to the Red Protector" serves as a significant demonstration for Mongolians' contributions towards Buddhist pujas and prayers. Agvaanchultem Lama, who was renowned as a Mother Tara Lama of Nomgon Monastery, wrote a commentary on this text, titled, 'Coral Ornament of Sublime Ones' Minds Recitation and Commentary on Offering All Fulfilments to a Dharma Guardian Red Protector'.